

БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД, СУРГУУЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧНЫ СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



“ТУНГААМАЛ ТӨВ” ТББ

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ	
I. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	3
II. УДИРТГАЛ	5
III. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	9
3.1 Сургуулийн бүс буюу гадаад орчин	11
3.2. Сургуулийн барилга байгууламж, анги танхим, дотоод орчны стандарт	17
IV. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	25
ХАВСРАЛТ	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Германы сургуулийн орчинд тавигддаг шаардлагаас.....	9
Хүснэгт 2:НҮБ-ын Хүүхдийн сангийн сургуулийн эрүүл ахуйн стандартаас.....	9
Хүснэгт 3:Сургуулийн дотоод орчны талаарх судалгааны дүн.....	21
Хүснэгт 4: Техник хэрэгслэлийн хангамжийн талаарх судалгааны дүн.....	22
Хүснэгт 5:Сурлагын чанарын үзүүлэлт \2016-2017он XII анги\.....	23
Хүснэгт 6:Боловсролын үйлчилгээний орчныг хяналтын хуудсаар үнэлсэн дүн.....	26

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1: Стандартын хэрэгжилтийн талаарх судалгаа.....	11
График 2: Сургуулийн гадаад орчны ээлтэй байдлын талаарх судалгааны дүн.....	12
График 3: Сургуултийн орчин дахь автомашины хөдөлгөөний талаарх судалгааны дүн ..	13
График 4: Сургуулийн орчин дахь явган хүний гарцны талаарх судалгааны дүн.....	13
График 5: Сургуулийн орчин дахь гэрлэн дохионы талаарх судалгааны дүн.....	14
График 6: “Сургуулийн бүс орйтож байна” тэмдгийн талаарх судалгааны дүн.....	15

График 7: “Хүүхэд” тэмдгийн талаарх судалгааны дүн	15
График 8: Хурд сааруулагчийн талаарх судалгааны дүн.....	15
График 9: Сургуулийн орчинд гарч болох эрсдлийн нөхцлийн талаарх судалгааны дүн	17
График 10: Сургуулийн орц, гарцын талаарх судалгааны дүн.....	17
График 11: Сургуулийн гадна талын гэрэлтүүлгийн талаарх судалгааны дүн.....	18
График 12: Сургууль орчмын хальтиргааны талаарх судалгааны дүн.....	18
График 13: Сургуулийн барилгын талаарх судалгааны дүн.....	19
График 14: Анги, танхимын хүрэлцээний талаарх судалгааны дүн.....	19
График 15: Сургуулийн удирдлага, багш нарын ажиллах нөхцлийн талаарх судалгааны дүн	20
График 16: Агааржуулалтын системийн талаарх судалгааны дүн.....	21
График 17: Номын сангийн талаарх судалгааны дүн.....	22
График 18: Сургуулийн орчин, сурлагын чанарын хамаарлын талаарх судалгааны дүн	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

- 1.НҮБ-Нэгдсэн Үндэстний байгууллага
- 2.БСШУСЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
- 3.НХХЯ- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
- 4.ИТХ-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

I. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. Үнэлгээний зорилго, арга зүй, үйл явц

Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлаг, Монгол Улсын Засгийн газраас хамтран “МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ” санаачилгыг хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний хүрээнд боловсрол, эрүүл мэндийн 4 өөр хөтөлбөрийн хэрэгжилтийг нийслэлийн 3 (Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй) дүүргийн хэмжээнд үнэлэх ажлыг эхлүүлсэн юм. Эдгээр хөтөлбөрийн нэг болох “Боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг “Тунгаамал төв” төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа болно.

Үнэлгээний ажлын зорилго нь:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдэд боловсролын чиглэлийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийж, аргачлал, зөвлөмж боловсруулна.

Үнэлгээний асуултууд:

Үнэлгээний хүрээнд дараах үндсэн асуултыг тавьж, хариулт олох болно. Үүнд:

- 1.Эцэг эх, сурагчид, багш нар, сургуулийн удирдлага, төрийн байгууллагууд сурах орчны нөхцөл байдлыг хэрхэн үнэлж байна вэ?
- 2.Батлагдсан стандартуудын хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүд юу вэ?
- 3.Сурах орчин нь сургалтын чанарт нөлөөлөх үү?
- 4.Сурах орчинг сайжруулахад зарцуулж буй төсөв, хөрөнгө ямар байна вэ?

Үнэлгээний аргачлал:

Дээрх үнэлгээний асуултад хариулахын тулд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулж ашигласан. Үүнд сурах орчны стандартыг зохицуулсан хууль эрх зүйн хүрээг тодорхойлох, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг тус бүрээс хоёр сургуулийг сонгож, сурах орчныг үнэлэх, БСШУЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Боловсролын газар, дүүргүүдийн холбогдох хэлтсүүдийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулах, сургуулийн сурагчид, эцэг эх, багш, удирдлагуудтай ярилцлага хийх, цахим хэлбэрээр асуулга авах зэрэг судалгааны аргуудыг ашигласан болно.

Төсөл хэрэгжүүлэгч баг нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн 53, 84 дүгээр сургууль, Сонгинохайрхан дүүргийн 62, Ирээдүй цогцолборын 1 дүгээр ахлах сургууль, Чингэлтэй дүүргийн 17, 24 дүгээр сургуулиуд, дүүргүүдийн холбогдох байгууллага, хэлтсүүд дээр ажиллалаа. Сургуулиудыг сонгохдоо сургуулийн ачаалал, байршил, гэр хорооллын болон орон сууцны, холимог байрлалтай, асрах сургуулийн сурагчид суралцдаг зэрэг

онцлогийг харгалзсан. Судалгаанд сургуулийн удирдлагыг 100 хувь, багш нарын 10 хувь, ахлах ангийн сурагчид, эцэг эхийн 5 хувийг хамруулсан болно.

Төслийн үнэлгээний ажлын хүрээнд сургуулийн удирдлага, багш, үйлчилгээний ажилтан, сурагч, эцэг эх нийт 450 хүнтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, уулзалтыг зохион байгуулав. Цахим судалгаанд нийт 567 хүн, үүнээс сургуулийн захирал, удирдлага 35, багш 198, сурагч 299, эцэг, эх 35 хүн оролцсон болно. Судалгаанд нийт 1069 хүн хамрагджээ.

1.2. Үнэлгээний хязгаарлагдмал байдал

-Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрийн хэрэгжилтийг зөвхөн нийслэлийн 3 дүүргийн түвшинд авч үзсэн.

-Хөтөлбөрийн зөвхөн 1 зорилт буюу сургуулийн орчин ямар байгаа талаарх хэрэгжилтийг үнэлсэн бөгөөд бусад зорилтуудыг авч үзээгүй болно.

II. УДИРТГАЛ

Олон Улсын стандартчлалын байгууллагаас стандартыг материал, бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний зорилгыг бүрэн биелүүлэхэд шаардагдах, байнга ашиглах боломжтой шаардлага, нарийвчилсан заавар, удирдамж, шинж чанарыг тусгасан баримт бичиг гэж тодорхойлсон байна. Манай улсын хувьд “Боловсролын салбарын стандарт бол бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тодорхой хэмжээг хангахын тулд салбарын мэргэжлийн ажлын хэсэг болон техникийн шинжээч нараас боловсруулсан, зөвшилцлийн зарчим дээр үндэслэсэн албан ёсны баримт бичиг” гэж тодорхойлдог. Стандартыг үндэсний хууль тогтоомж, техникийн зохицуулалт болон үнэлгээ, хяналт шалгалтын шалгуур болгон авч хэрэглэдэг. Стандарт нь байх ёстой түвшинг тодорхойлсон баримт бичиг юм.

Монгол Улсын Засгийн газраас 2010 онд баталсан “Боловсрол үндэсний 2010-2021”, хөтөлбөрийн Стратегийн зорилт 2-т “Шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан боловсролын стандартын шалгуурыг нарийвчлан тогтоох” хүрээнд “боловсролын үйлчилгээний орчны стандартыг боловсруулж мөрдөх” гэж заасан байна.

Сургуулийн болон сургуулийн эдэлбэр газрын орчин нь сурагчид, багш ажилчид, эцэг эхчүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чухал нөлөөтэй юм. Сургуулийн барилга байгууламж, түүний эргэн тойронд хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлөөс ангид байж, хүүхдийн суралцах үйл явцыг дэмжих ёстой. Сургуулийн орчин хүүхдийн сурлагын амжилтанд сөргөөр, эсвэл эерэгээр нөлөөлөх боломжтой гэдгийг олон судалгааны үр дүнгээс харах боломжтой. Сургуулийн орчинг аюулгүй, эрүүл байлгахын тулд хүнсний аюулгүй байдал, халдвар хамгаалал, цэвэр усны хангамж, дотоод агаарын чанар, анги танхимын гэрэлтүүлэг, тоглож наадахад аюулгүй талбай, хүчирхийлэл болон бусад аюулаас урьдчилан сэргийлэх гэх мэт олон төрлийн бодлого, дүрэм, стандартыг батлан гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай. Манай улсын хувьд ерөнхий боловсролын сургуулийн сурах орчинг Боловсролын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, холбогдох яамдын сайд нарын баталсан дүрэм, журам, Стандарчилал хэмжил зүйн газраас баталсан 30 орчим стандарт, барилгын хийц, даац, дэд бүтцийн холболт зэргийг тогтоосон 200 гаруй норм, нормативуудаар зохицуулж байгаа бөгөөд дээр дурдсан сургуулийн үйлчилгээний орчны стандартыг одоогоор боловсруулаагүй, батлаагүй байгаа болно.

Шигтгээ 1: Бага дунд боловсрол, хүүхдийн асуудалтай холбоотой манай улсад мөрдөгдөж байгаа стандартуудаас:

- 1.MNS 6440:2014 Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага
- 2.MNS ISO 13216-3:2016 Автозамын тээврийн хэрэгсэл. Хүүхдийн хамгаалалтын системийн төхөөрөмж, хэрэгслүүд болон тээврийн хэрэгслийн дотор бэхэлгээ
- 3.MNS 6444 : 2014 Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага
- 4.MNS 5418: 2008 Бага, дунд боловсролын сурах бичигт тавих шаардлага.
- 5.MNS 6582 : 2016 Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага
- 6.MNS 6583 : 2016 Сурагчийн ширээ ба сандал. Турших арга
- 7.MNS 6232:2011 Сурагчийн дүрэмт хувцасны хагас ноосон даавуу. Техникийн шаардлага
- 8.MNS ISO 4415:2012 Хувцасны өмсгөл хэмжээний тэмдэглэгээ.
- 9.MNS ISO 4416:2012 Хувцасны өмсгөл хэмжээ. Эмэгтэй хүний болон охидын нимгэн хувцас
- 10.MNS 5420-2:2004 17 х. Бага, дунд боловсрол. Бага боловсрол
- 11.MNS 5420-3:2004 18 х. Бага дунд боловсрол. Суурь боловсрол

Үнэлгээний баг дээр дурьдсан баримт бичгийн агуулгын судалгааг хийсэн бөгөөд Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлд боловсролын байгууллагын сургалтын орчны талаар тусгагдсан болно. Энэ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасан бөгөөд 42.3 дахь хэсэгт “Цэцэрлэг, сургуулийн барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хоол хүнсний зүйл болон суралцагчийн эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсрол, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж мөрдүүлнэ” гэж тодорхойлсон байна. БСШУ-ны сайдын 2010 оны 471 дүгээр тушаалын хавсралтын 6.3 дахь хэсэгт заасан “Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан, зориулалтын, барилга байгууламжтай байх”, БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалын хавсралтын 4-т заасан “...ангийн нэг бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо 35-аас ихгүй байх...” гэсэн зохицуулалтууд, MNS 6444:2014 Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага, MNS 6582: 2016 “Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага” стандартууд, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын барилгын дүрэм, “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм”-д заасан шаардлагуудын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн болно.

“Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм”-д зааснаар:

“...3.5.Сургуулийн эдэлбэр газар нь 1,5 м-ээс багагүй өндөртэй ногоон байгууламж эсвэл хашаагаар хүрээлэгдсэн байна. 4.9.Ерөнхий боловсролын сургуулийн барилга 3 давхар байх нь ашиглалтад тохиромжтой. Харин 4 давхар төлөвлөх нөхцөлд Барилгын дүрмийн 31-03-03-ын шаардлагыг баримтлана.

4.10.Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг архитектурын зориулалтаар нь хичээллэх анги танхим болон нийтээр ашиглах үйл ажиллагааны зориулалттай танхим гэсэн 2 үндсэн хэсэгт хуваана.

4.12.Ерөнхий боловсролын сургуулийн эмнэлгийн хэсэгт эмчийн өрөө, шүдний эмчийн өрөө, сорох төхөөрөмжтэй эмчилгээний өрөө, сэтгэл зүйчийн өрөө байхаас гадна бие даасан ариун цэврийн өрөө байна.

4.13. Үзвэрийн заалын 1 суудалд 0,65 м² талбай оногдохоор тооцож ээлжиндээ нийт сурагчдын 60 хүртлэх хувь нь хамрагдахаар тооцох нь зүйтэй. Заалны дэргэд сурагчид болон жүжигчдэд зориулсан ариун цэврийн өрөөнөөс гадна кинопроекцийн өрөө, хөгжмийн хэрэгсэл, тайзны засал чимэглэлийн агуулах, хувцас хадгалах өрөө байна.

4.15. Номын сангийн уншлагын танхимын талбайг 1 сурагчид 0.6м²-аас багагүй талбай оногдохоор тооцох.

Ерөнхий боловсролын сургуулийн барилгаас тухайн сургуульд хамааралтай авто зогсоол хүртлэх зайг авто тээврийн хэрэгсэлийн хүчин чадалтай уялдуулж дараах зарчмыг баримтлан төлөвлөх ёстой.

- 10 авто тээврийн хэрэгсэл 15 м
 - 11-100 авто тээврийн хэрэгсэл 25 м
 - 101-300 авто тээврийн хэрэгсэл 50 м байна.
- Бага ангийг 1-ээс дээш давхарт төлөвлөхгүй байх

-6 настай 1 хүүхдэд зориулсан ширээний хамгийн бага хэмжээ 600x400x550(h) мм, сандалын хэмжээ 350x320x250 мм (хагас түшлэгтэй) байхаар тооцно. Ангийн үндсэн талбайгаас гадна тоглох орон зай, номын сангийн булан, үзүүлэн материалын болон хувцасны өлгүүрийн талбай зэргийг нэмж ангийн нийт талбай, эзэлхүүнийг тодорхойлох нь зүйтэй. Ангийн талбай ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор сурагчдийн хувцасны шүүгээг хананы хөндийд төлөвлөж болно. Ангийн самбарыг сурагч, багш зэрэг ашиглах боломжийг харгалзан шалны түвшнээс 600-650 мм-ээс багагүй өндөрт байрлуулах нь тохиромжтой. Сурагчдыг ширээнд аль болох ганцаараа суухаар тооцох.." гэх мэт нормативуудыг тодорхойлсон байна.

Үүнээс харахад одоо байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дүрэм, стандарт, норм, нормативууд нь материаллаг асуудлуудыг ихээхэн анхаарсан байгаа боловч боловсролын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой агаарын чанар, ариун цэвэр, халдвар хамгаалал, гэрэлтүүлэг, хүүхдүүд тоглох болон биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл зэргийг нарийвчлан зохицуулаагүй байна.

Шигтгээ 2: БСШУСЯ-ны мэргэжилтний ярилцлагаас: Сургуулийн орчны стандартыг боловсруулж батлуулах шаардлагатай байгаа. Стандарт боловсруулах нь цаг хугацаа шаардсан, өргөн цар хүрээтэй ажил. Баг бүрдүүлж, яам, нийслэл, дүүргээс мөнгө гаргах хэрэгтэй боловч аль нь ч өгч чаддаггүй. Тийм болохоор энэ ажлыг санхүүжүүлэх төсөл олох хэрэгтэй байгаа..."

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2015 оны судалгааны дүнгээс харахад хөгжиж буй болон хөгжингүй олон оронд сургуулийн орчны стандарт гэж тусгайлсан баримт бичгийг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангадаг байна. Стандартын баримт бичиг нь сургуулийн барилга байгууламжинд тавих шаардлага, ариун цэвэр, халдвар хамгааллын арга хэмжээ, байшин доторх агаарын чанар, түүний дотор хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, чийг, мөөгөнцөрөөс хамгаалах арга хэмжээ, хүүхдийн хөдөлгөөн, идэвхтэй байдлыг дэмжих биеийн тамирын заал, тоглоомын талбай зэргийг тусгаж өгсөн байдаг байна. Жишээ нь: Германы сургуулиудад орчинд дараах шаардлагыг тавьж, мөрдлөгө болгодог байна.

Хүснэгт 1: Германы сургуулийн орчинд тавигддаг шаардлага

Физик хүчин зүйл	Хэмжих арга	Стандарт шаардлага
Агаарын солилцоо, агааржуулалт	СО ₂ -ийн шинжилгээ	1000 ppm
Тасалгааны температур	Термо гидрометр	20-26° С
Харьцангуй чийгшил	Термо гидрометр	30-50%
Тасалгааны цуурай	Цуурайг хэмжих төхөөрөмж	0,5 s- 20%
Тасалгааны гэрэлтүүлэг	Lux meter	300 lux

Түүнчлэн, НҮБ-ын Хүүхдийн сангаас сургуулийн ариун цэвэр, цэвэр болон бохир усны хангамж, эрүүл ахуйн шаардлага стандартуудыг боловсруулсан байдаг. Ялангуяа төсөв хөрөнгө хязгаарлагдмал нөхцөлд эдгээр стандартуудыг хэрхэн хангах талаар олон судалгаа, нөлөөллийн ажлуудыг хийгээд байна. Эдгээр стандартын заримаас дурьдвал:

Хүснэгт 2: НҮБ-ын Хүүхдийн сангийн сургуулийн эрүүл ахуйн стандарт

Стандарт	Энгийн сургууль	Дотуур байртай сургууль
Ундны цэвэр ус	Өдөрт 5 литр	Өдөрт 20 литр
Бие засах суултуур	25 охин тутамд 1, эмэгтэй ажилчдад 1 50 хөвгүүн тутамд 1, эрэгтэй багш ажилчдад 1	25 охин тутамд 1, эмэгтэй ажилчдад 1 50 хөвгүүн тутамд 1, эрэгтэй багш ажилчдад 1
Цэвэрлэгээ	Халдваргүйжүүлэгчтэй халуун усаар нойтон цэвэрлэгээг өдөр болгон хийнэ	Халдваргүйжүүлэгчтэй халуун усаар нойтон цэвэрлэгээг өдөр болгон хийнэ
Бохир, хог хаягдлыг зайлуулах	Хуурай хог хаягдлыг өдөр болгон зайлуулна	Хуурай хог хаягдлыг өдөр болгон зайлуулна
Хоол боловсруулах	Тогооч, ажилчдын эрүүл мэнд, халдвар хамгаалал Халуун хоолны үйлчилгээ Хүйтэн, хагас боловсруулсан хоолны үйлчилгээ	Тогооч, ажилчдын эрүүл мэнд, халдвар хамгаалал Халуун хоолны үйлчилгээ хүйтэн, хагас боловсруулсан хоолны үйлчилгээ

III. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Манай Улсад сургуулийн орчны стандарт гэж байхгүй учраас, сурах орчны минимум стандартыг Хөгжиж буй орнуудын боловсролын төлөө Агентлагийн сүлжээнээс дараах байдлаар авч үзснийг мөрдлөгө болгов. Үүнд:

Орчны стандарт 1. Аюулгүй байдал, хамгаалалт:

- Сургуульд нэвтрэх зам, маршрут нь аюулгүй байх, (байршил)
- Сургуулийн барилга, барилгын бүтэц бүгдэд аюулгүй, нэвтрэх боломжтой байх

-Сургуулийн барилга нь чанарын стандартыг хангасан байх (хийц материал, тоноглол, зохион байгуулалтын хувьд)

-Суралцагчдад ойр дөт байх (Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад бүлэгт суралцахад нь таатай байдлаар баригдсан эсэх)

Орчны стандарт 2: Сургуулийн дотоод орчин

- Анги дотор сурагчид багш нарын хооронд хангалттай зайтай эсэх
- нэг ангид байх суралцагсдын дээд хязгаарыг давахгүй байх.
- Гэнэтийн аюулын нөхцөлд аюулгүй гарц, орц багш суралцагчдад хүрэлцээтэй байх
- Ариун цэврийн өрөө хүйсээр, насаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийцсэн тоогоор байх
- Хогийн сав, хогийн цэгтэй байх
- Бохирын системтэй байх
- Цэвэр ус, 00-н өрөөнд хангалттай устай байх гэх зэргээр тогтоосон байна.

Хөндлөнгийн үнэлгээг тодорхой үзүүлэлтийн хүрээнд дүүргийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Боловсролын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, сургуулийн удирдлага, багш, эцэг эхийн төлөөлөл, сурагчдаас хаалттай асуулга судалгаа авах, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага авах, хяналтын хуудас ашиглан үнэлэх, ажиглалт хийх зэрэг аргаар явуулсан.

Сургалтын орчныг үндсэнд нь дараах хэсэгт багцлан хуваан үзэж хууль, дүрмээр тогтоосон болон хуулиар зохицуулагдаагүй ч байх ёстой стандарт шалгуурын хүрээнд үнэлгээг хийв. Үүнд:

1. Сургуулийн бүс (гадаад орчин), түүний аюулгүй байдал, хамгаалалт

Энэ хэсэгт сургуулийн бүс, гадаад орчин нь суралцагчын болон багш, ажилтнуудад ямар нэгэн эрсдэл байгаа эсэх, сургуульд нэвтрэх зам аюулгүй байх, автомашины хөдөлгөөн болон бусад учирч болох эрсдэлээс хамгаалагдсан байх.

2. Сургуулийн барилга байгууламж, анги танхим, дотоод орчны стандарт

Энэ хэсэгт сургуулийн барилга, байгууламж нь хийц материал, тоноглол, дотоод

зохион байгуулалтын хувьд стандартыг хангасан байдал, сургуулийн барилга анги танхим, захиргаа, ариун цэврийн өрөө, чийрэгжүүлэлтийн анги танхимаар бүрэн хангагдсан эсэх, сургуулийн барилга байгалийн гамшигт үзэгдэл болох гал, газар хөдлөх, шуурга болон бусад байгалийн аюул, үзэгдэлд бөх бат хамгаалагдсан байх, түүнд тэсвэртэй байх, ариун цэврийн өрөөг хүйс, нас, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад нийцсэн тоогоор байх, зориулалтын, эрүүл ахуйн нөхцөлийг хангасан байдал, хогийн сав, хогийн цэгтэй байх, цэвэр усны болон бохирын системтэй байгаа эсэх, сургууль дотор зорчин явах тэмдэг тэмдэглэгээ, аюулын гарц бий эсэх гэсэн асуудлуудаар үнэллээ.

Боловсролын байгууллагын орчныг сайжруулахаар улс, орон нутгийн удирдлагаас ихээхэн анхаарч, жил бүрийн төсөвт нилээдгүй хэмжээний мөнгийг тусган, заурцуулж байна. 2017 онд Улсын төсөв болон улсын төсвийн концессоор хэрэгжиж буй 6 сургууль, 4 сургуулийн өргөтгөл ашиглалтад орж, сургуулийн хүчин чадлын хэмжээ 7800 суудлаар нэмэгджээ.

Гэвч сургуулиудад мөрдөгдөж байгаа зарим стандартууд төсөв, мөнгөний дутагдалтай байдлаас шалтгаалан бүрэн хэрэгждэггүй, \Жишээ нь: хурд сааруулагчтай байх, замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ тавьсан байх г.м.\ мөн зарим шаардлагатай стандартууд батлагдаагүй, \сургуулийн орчны стандарт\, зарим нь сурагчдын тоо нормоос хэт давсан учраас хэрэгжүүлэх боломжгүй байдаг байна. Стандартын хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага, Стандарчлал, хэмжил зүйн газраас хяналт тавьж байгаа боловч, ажлын нэгдсэн уялдаа холбоо сайнгүй байна.

Төслийн багаас хийсэн судалгаагаар сургуулийн удирдлага сургуулийн дотоод, гадаад орчны үндэсний стандартыг мэдэх үү? гэсэн асуултанд “Тийм” гэж 53.5% “Үгүй” гэж 46.5% нь хариулсан байна. Энэ хариулт нь мөрдөгдөж байгаа стандартуудыг хэвлэж худалдаж байгаатай холбоотой. Сургуулиуд стандартыг тэр бүр худалдан авдаггүй, төсөв, хөрөнгө оруулалтын хомсдолтой байдлаас шалтгаалан хэрэгжилтийг хангахад зарим хүндрэл учирдаг байна.

Ярилцлагын үеэр оролцогчдоос стандартын хэрэгжилт ямар байгаа талаар асуухад “Муу” гэж 14.8%, “Дунд зэрэг” гэж 37.0% “Сайн” гэж нийт оролцогчдын 48.2% нь хариулсан байна.

График 1: Стандартын хэрэгжилтийн талаарх судалгаа




Шигтгээ 3: Дүүргийн Боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтний ярилцлагаас:

“Сургуулийг 3 ээлжээр хичээллэж байгаа энэ үед стандартын хэрэгжилтийн талаар ярих ямар ч боломжгүй, стандартыг хэрэгжүүлбэ гэвэл боловсролын байгууллагад төсвийг нь бүрэн өгч байх, сурагчдыг зөвхөн 2 ээлжээр хичээллүүлэх, багш нарын нэр хүндийг өсгөх асуудалд анхаарах хэрэгтэй.....”

3.1 Сургуулийн бүс буюу гадаад орчин

Сургуулийн гадаад орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдал, орчны ногоон байгууламж, гэрэлтүүлэг, камержуулалт, халтиргаа, гулгаа, зам, талбайн тохижилт, бохир, цэвэр усны худгийн таглааны битүүмжлэл, хогийн цэгийн байрлал, гарц, орцын хүрэлцээ, гэмт хэрэг, зөрчилд өртөх магадлал, сургуулийн орчимд барилгын ажил хийгдэж байгаа эсэх, ухсан нүх, овоолсон шороо, далан байгаа эсэх, сургууль орчмын дэлгүүр, ТҮЦ-д хүүхдэд худалдаалах хориотой бүтээгдэхүүн худалдаалж байгаа эсэх зэргийг хамааруулж үзсэн болно.

График 2: Сургуулийн гадаад орчны ээлтэй байдлын талаарх судалгааны дүн




Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан “MNS 6444: 2014 Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага” стандарт нь сургуулийн орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилготой. Энэ стандартад зааснаар “Сургууль орчмын бүс” тэмдгийг сургуулийн орчим (200 м дотор) замын хэсгийн өмнө байрлуулах, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг, тэмдэглэгээг хаана, ямар хэмжээнд байрлуулах асуудлыг зохицуулсан болно.

Бидний ажилласан 6 сургуулийн орчинд эдгээр тэмдэглэгээ бүрэн хийгдээгүй, хурд сааруулагч 2 сургуульд хийгдээгүй, хийгдсэн байгаа нь тухайн сургуулиас хол байрлуулсан байх жишээтэй. Эдгээр тэмдэглэгээ болон хурд сааруулагчийг хийлгэхэд

холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах, тодорхой хэмжээний хөрөнгө, мөнгө шаардлагатай гэх мэтийн хүндрэл байдаг учраас сургуулийн захиргаанаас илүүтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Замын цагдаагийн газар анхаарч, стандартын шаардлагыг хангуулах арга хэмжээ авах, үзлэг шалгалтыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хийх хэрэгтэй байна. Судалгаанд оролцсон эцэг эх, сурагчид, багш, сургуулийн удирдлагын дунджаар 60.1% нь буюу олонх нь сургуулийн орчинд автозамын хөдөлгөөн их, энэ нь сурагчид эрсдэлд орох магадлал өндөртэй гэж үзжээ. Ялангуяа эцэг, эхчүүдийн 88.6% нь автомашины хөдөлгөөн ихтэй гэж үзсэн байна. Тиймээс, энэ стандартыг хэрэгжүүлэх нь сургууль орчмын аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

График 3: Сургуултийн орчин дахь автомашины хөдөлгөөний талаарх судалгааны дүн



Сургууль руу нэвтрэхэд хөндлөн гарах шаардлагатай автозам дээр явган хүний гарц, жолоочид анхааруулах тэмдэглэгээ байдаг уу? Хэрэв “байдаг” гэж үзэж байгаа бол тэдгээрийн нөхцөл байдлыг 1- “шаардлага хангахгүй”, 2 -“шаардлагыг хагас дутуу хангана” 3-“шаардлагыг бүрэн хангана” гэсэн оноогоор үнэлнэ үү? гэсэн асуултад судалгаанд оролцогсад дараах байдлаар хариулсан болно.

График 4: Сургуулийн орчин дахь явган хүний гарцны талаарх судалгааны дүн




График 5: Сургуулийн орчин дахь гэрлэн дохионы талаарх судалгааны дүн




график 6: "Сургуулийн бүс ойртож байна" тэмдгийн талаарх судалгааны дүн




График 7: “Хүүхэд” тэмдэгийн талаарх судалгааны дүн




График 8: Хурд сааруулагчийн талаарх судалгааны дүн




Явган хүний гарц нь зохих газраа байрласан, хангалттай гарцтай эсэх асуудлаар сургуулийн удирдлагын 57.1% нь шаардлага бүрэн хангасан гэсэн байхад эцэг эхчүүд, сурагчдын 31% нь л шаардлага хангасан гэж нэлээд зөрүүтэй үнэлжээ. Гэрлэн дохионы шаардлага хангасан байдлыг оролцогчдын 30.7 хувь нь мэдэхгүй гэж, шаардлага хангасан гэж 18,5%, дутуу хангасан гэж 18,5%, шаардлага хангаагүй гэж 10,2% нь үзжээ. Оролцогчдын хувьд уг асуултанд санал нэлээд хуваагдсан нь уг асуултыг шууд хариулахад нэлээд төвөгтэй байсантай холбоотой.

Түүнчлэн “Сургуулийн бүс ойртож байна”, “Хүүхэд” зэрэг тэмдгүүдийн талаар асуулгад оролцогчдын 40% нь мэдэхгүй эсвэл огт хариулт өгөөгүйгээс үзэхэд уг асуултад мөн шууд хариулахад төвөгтэй байсан нь ажиглагдаж байна.

Харин хурд сааруулах тэмдэгийн хувьд оролцогчдын 35.3% нь шаардлага бүрэн хангасан, 27.5% нь дутуу хангасан гэж үзэж буй нь бусад тэмдэгийг бодвол машины хурд сааруулах тэмдэг тавьж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байдал сайжирч байгааг харуулж байна. Түүнчлэн өглөө хичээл орох, өдөр хичээл тарах цагаар зохицуулагч эцэг, эхийг ажиллуулж байгаа нь бага насны хүүхдүүдийг сургуулийн бүсэд аюулгүй зорчих боломжийг олгосон үр дүнтэй ажил болжээ.

Та сургуулийн гадаад орчны нөхцөл байдлыг осол гарах, сурагчид бэртэж, гэмтэх, бусад эрсдэл гарч болох нөхцөл байдлыг судалгаанд оролцогчдын 42% нь эрсдэлтэй, 12,7% нь хэвийн гэж үзсэн байна.


График 9: Сургуулийн орчинд гарч болох эрсдлийн нөхцлийн талаарх судалгааны дүн



Асуулга судалгаанд оролцогчдын сургуулийн орчин, бүс нь ерөнхийдөө сурагчдад хэр ээлтэй вэ? гэсэн асуултад багш нарын 51.5% нь дундаас доогуур, 58.5% нь дунд зэрэг ба ээлгүй, эцэг эхчүүдийн 57.2% нь мөн дунд ба түүнээс доогуур үнэлгээ өгсөн байна. Харин сургуулийн удирдлагын 31.5% нь дундаас доогуур үнэлсэн нь тэд сургуулийн бүс, гадаад орчны нөхцөлийг бусад оролцогчдоос илүү үнэлсэн байна. Судалгаанд оролцогчдын 52.4% нь сургууль орчмын зам талбай хальтиргаатай, 47.8% нь утаа ихтэй учир үзэгдэх орчин хязгаарлагдмал, 43.0% гудамжны хөл хөдөлгөөн ихтэй учир зорчиход бэрхшээлтэй гэж доогуур үнэлжээ.

Шигтгээ 4: Төрийн өмчийн сургуулиудын хамран сурах тойргийн сургуулийн сурагчид хамгийн ойрхон нь сургуулиас 50 метр газраас ирж байгаа бол хамгийн хол нь 30 км газраас буюу Жаргалант тосгоноос 74-р сургуульд ирдэг байна.
 Эх сурвалж: Багштай хийсэн ярилцлагаас

График 10: Сургуулийн орц, гарцын талаарх судалгааны дүн



- Сургуулиуд өөрийн автомашины зогсоолгүй, зэргэлдээх байгууллагууд нь сурагчдын зорчих хэсэг дээр машинаа байрлуулж хөдөлгөөнд саад учруулдаг, сургуульдаа ирэх, буцахдаа 1-4 зам хөндлөн гардаг зэрэг нь эрсдэлтэй байгаа учраас сургуулийн орчинд гүүрэн болон нүхэн гарцууд барих шаардлагатай байна.
- Цахим тоглоомын газар, хүнсний дэлгүүр сургуулийн гаднах бүсэд ашиг олох зорилгоор байршиж, хүнсний баталгаагүй бүтээгдэхүүн, тамхи зөвшөөрөлгүйгээр худалдаалдаг, түүнд дүүргийн цагдаа, Мэргэжлийн хяналтын хэлтсээс байнга шалгалт хийх хүний нөөц дутмаг тул бүрэн хянах боломжгүй байдаг байна.
- Сургуулийн хашаан доторх орчны халтиргаа, гулгаа байхгүй боловч сургуулийн хашааны гаднах гудамж, замын хальтиргаа их, явган хүний замууд ихээхэн эвдрэлтэй байна.

График 11: Сургуулийн гадна талын гэрэлтүүлгийн талаарх судалгааны дүн





График 12: Сургууль орчмын замын хальтиргаатай байдлын талаарх судалгааны дүн




3.2. Сургуулийн барилга байгууламж, анги танхим, дотоод орчны стандарт

Монгол Улсад сургуулийн барилгын стандарт гэж тусгайлсан стандарт байдаггүй, харин барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 209 норм, норматив батлагдсан байдаг бөгөөд түүний дагуу боловсролын байгууллагын барилгууд баригддаг байна.

Төсөл хэрэгжүүлэгч баг сургуулийн барилга, байгууламж нь хийц материал, тоноглол, дотоод зохион байгуулалтын хувьд зарим норм, нормативуудад заагдсан үзүүлэлтүүдийг хангасан талаар талуудаас судалгаа авсан болно.

Таны бодлоор сургуулийн барилга зохих шаардлагыг хэр зэрэг хангаж байна вэ? (Үнэлэхдээ барилгын хийц, чанар, барилгын материал, барилгын насжилт, дээвэр, цонх, шал, сантехник, дулаан хангамжийн байдал, барилгын гадаад, дотоод өнгө үзэмж зэрэг үзүүлэлтийг бүхэлд нь харж үнэлнэ.) гэсэн асуултанд “шаардлага огт хангахгүй”, “хангах төдий гэсэн хариулт”-ыг хамтатган авч үзвэл сургуулийн удирдлагын 29% (6%, 23%), багш нарын 39% (4%, 35%), эцэг эхчүүдийн 57% нь сургуулийн барилга байгууламжыг стандартын шаардлагыг хангах төдий байна гэж үзсэн байна. Энэ байдлыг газар дээр нь сургуулиуд дээр очиж ажиглалт хийхэд барилгын насжилт өндөр, дээвэр, хана нь муудсан их засвар хийх шаардлагатай, анги бүрт агааржуулалтын системгүй гэх мэт асуудлууд байна. Одоо ажиллаж байгаа 700 гаруй сургуулийн 150 гаруй сургуулийн барилга нь 40 жилээс дээш насжилттай, нийт сургуулийн барилгын 20-30 хувийг цаашид ашиглах боломжгүй гэсэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дүгнэлт гарсан, нийслэл хотод 3 ээлжээр хичээллэж байгаа 28 сургууль байна. Бидний ажилласан сургуулиуд ч 63-29 жилийн насжилттай, ачаалал нь 60-205 хувьд хүрсэн байна.

График 13: Сургуулийн барилгын талаарх судалгааны дүн



Сургуулийн хашааны хаалга хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нээгдэхэд хялбар байдаг уу гэсэн асуултад 61% нь үгүй, ийм хүүхдэд зориулсан замтай юу? гэсэн асуултад 64% нь үгүй, зориулалтын шатгүй гэж 62%, ариун цэврийн өрөөнд зориулалтын тусгай суултуур байдаггүй гэж 83% нь хариулсан нь сургалтын орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ээлгүй байгааг илтгэж байна.

Сургуулийн барилга анги танхим, ариун цэврийн өрөө, чийрэгжүүлэлтийн танхимаар бүрэн хангагдсан эсэх гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан сурагчдын 42% нь анги танхимын хүрэлцээ хангамжийг муу эсвэл дунд гэж, багш нарын 68%, сургуулийн удирдлагын 55% нь мөн ингэж хариулсан нь нийслэл хотод сургуулийн ачаалал стандарт хэмжээнээс хэт давсныг илтгэж байна. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн хүн амын өсөлтөөр жишээ болгоход 2012 оноос 2017 онд хүн ам 20%-аар, нийт өрх нь 29%-аар өссөн байна. Мөн дүүргийн төрийн өмчийн 25 сургуулийн хүчин чадал 22352 суудалтай байхад одоо 42925 хүүхэд суралцаж байна. Нэг ангид ногдох сурагчдын тоо 35-аас хэтрэхгүй байхаар тогтоосон норматив байдаг боловч 45-50 хүртэл хүүхэд хичээллэж байна. Сурагчдын тоо өссөнтэй холбоотойгоор багш нарын тоо ч нэмэгдсэн байна.

Сургуудиудад багш нарын контор, багш хөгжлийн төв гэсэн өрөөнүүд байгаа боловч энэ нь хүрэлцээгүй, багш хичээлдээ бэлтгэх, түр амрах боломжийг хангахгүй байна.

График 14: анги, танхимын хүрэлцээний талаарх судалгааны дүн





График 15: Сургуулийн удирдлага, багш нарын ажиллах нөхцлийн талаарх судалгааны дүн




Ахлах ангийн сурагчид биеийн тамирын хичээлийн заал хүртээмжгүй, ачаалал ихтэй, техник хэрэгслэлийн хангамж муу гэж ярьсан бөгөөд Нийслэлд байгаа 231 сургуулийн 130 нь л спорт заалтай байгаа нь үнэхээр асуудал байгааг харуулж байна. Сурагчид хичээлээс гадуур дугуйлан, секцэд хамрагдах, сургууль дээр биеийн тамираар хичээллэх боломж хязгаарлагдмал байгаагаас, цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхэд нь сөргөөр нөлөөлдөг хэмээн багш, сурагчид ярьж байв. Зарим сургуулиуд дээр биеийн тамирын зааланд нэг цагт 3 анги зэрэг хичээллэх, бага ангийн сурагчдын биеийн тамирын хичээлийг урлаг зааланд оруулж, зөвхөн спортын талаар мэдээлэл өгч байгаагаас хүүхдүүд хөдөлгөөний хомсдолд орох, улмаар дархлаа нь муудах, өвчлөмтгий болоход нь нөлөөлж байна.

Ариун цэврийн өрөөг хүйс, нас, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад нийцсэн байдлаар тохижуулсан эсэх, эрүүл ахуйн нөхцөлийг хангасан, цэвэр усанд холбогдсон эсэх гэсэн асуултад сургуулийн багш сурагчдын 38% хувь нь муу, дунд гэсэн үнэлгээ өгсөн байна.

Анги танхимын чийгшил, тоосжилт, гэрэлтүүлэг, халаалт, дулаан, ширээ, сандлын стандартын хэрэгжилт, самбар болон бусад техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдлын талаарх судалгааны дүнгээс:

Анги танхим доторх агаар хэвийн гэж нийт оролцогчдын 51%, анги доторх агаарыг хуурай гэж 33% нь дүгнэсэн нь зориулалтын агааржуулалтын системгүй, нэг ангид байх хүүхдийн тоо олон байгаатай холбоотой.

График 16: Агааржуулалтын системийн талаарх судалгааны дүн




Сургуулиудад байгаа ширээ, сандлыг монгол, хятад, японд үйлдвэрлэсэн, стандартад заасан хэмжээнээс 10-15 см-ын өндөр буюу намхан, ихэнх нь хэтэрхий хуучирсан, зарим ширээ хэт тод өнгөтэй, эвдрэл ихтэй, хүүхдийн хувцас урах магадлалтай байна. Сүүлийн жилүүдэд ахлах ангийн сурагчид өсгөлүүн болсон учраас ширээ, сандал нь намдах, багадах, хөдөлгөөнгүй олон цаг хичээлд сууснаар нурууны хөгжилд муугаар нөлөөлдөг талаар зарим багш, сурагчид ярьж байв.

Хүснэгт 3: Сургуулийн дотоод орчны стандартын хэрэгжилтийн талаарх судалгааны дүн

		Стандартын бус	Стандартын	Мэдэхгүй	Хариулаагүй	Нийт
1	Сандал	14%	59%	14%	13%	100%
2	Ширээ	14%	60%	12%	13%	100%
3	Самбар	11%	65%	10%	13%	100%
4	Гэрэлтүүлэг	7%	69%	11%	14%	100%
		Хүйтэн	Тохирсон	Халуун	Хариулаагүй	Нийт
5	Халаалт	9%	65%	13%	13%	100%

График 17: Сургуулийн номын сангийн талаарх судалгааны дүн



Сургуулийн номын сангийн хүрэлцээ хангамжийн байдлыг сургуулийн удирдлагын 26% нь, багш нарын 20%, сурагчид 15%, эцэг эхийн 3% нь “онц” гэж буурсан байдлаар үнэлсэн нь боловсролын үйлчилгээний хэрэглэгч болох сурагч, эцэг эхийн байр суурь, сургуулийн удирдлага, багш нарынхаас ялгаатай байгаа дүн гарсан. Жишээ нь: 62 дугаар сургуулийн номын сангийн багтаамж муу, хуучин ном ихтэй, хүйтэн байсан бол Ирээдүй цогцолборын 1 дүгээр ахлах сургууль нь уншлагын 2 танхимтай, сурагчид хичээллэх боломжоор бүрэн хангагдсан байсан.

Ахлах ангийн сурагчид элсэлтийн шалгалтанд бэлтгэх нэмэлт давтлага авах, дугуйлан секцэнд хичээллэх боломж муу, ачаалал их учраас анги, танхим хүрэлцээгүй, номын санд хэрэгтэй ном, сурах бичиг байдаггүй, сургалтын техник хэрэгслэл хомсдолтой зэрэг нь сургалтын чанарт муугаар нөлөөлж байгаа талаар байгаа талаараа ярьж байлаа. Мөн багш нар сурагчдыг ойлгож, сонсох, тэдгээртэй ганцаарчилж ярилцах байдал хангалтгүй, сэтгэл зүйчтэй байх хэрэгтэй гэсэн саналыг гаргаж байсан.

Асуулга судалгаанд оролцогчид ерөнхийдөө анги танхим дахь сургалтын, техник хэрэгсэл, лабораторын хүрэлцээ хангамж зэргийг дараах байдлаар үнэлсэн дүн байна.

Хүснэгт 4: Техник хэрэгслэлийн хангамжийн талаарх судалгааны дүн

Үзүүлэлт	Муу	Дунд	Сайн	Онц	Мэдэхгүй	Хариулаагүй	Нийт
1 Хэвлэх, хувилах тоног -төхөөрөмжтэй эсэх	13%	28%	27%	11%	5%	17%	100%
2 Сургуулийн дотор орчны гэрэлтүүлэг	4%	12%	44%	22%	1%	17%	100%
3 Биеийн тамирын хичээлийн хэрэгслийн хүрэлцээтэй байдал	10%	28%	27%	14%	4%	17%	100%
4 Хөгжмийн хичээлийн өрөөний тохижилт, хэрэгслийн хүрэлцээтэй байдал	17%	27%	19%	13%	6%	18%	100%
5 Физик, хими зэрэг шинжлэх ухааны хичээлийн лабораторийн хэмжилтийн багаж, хэрэглэгдэхүүн, урвалж, бодис	14%	29%	22%	10%	9%	16%	100%


	зэргийн хүрэлцээ хангамж							
6	Компьютерийн лабораторийн техник хэрэгслэлийн хүртээмж, ажиллагаа	11%	23%	31%	16%	3%	17%	100%
7	Анги, танхим доторх агаар	19%	27%	24%	8%	6%	16%	100%

Үнэлгээний дүнгээс харахад сургуулийн сурах орчинд сайжруулах асуудлууд олон байгааг харуулж байна. Тэдгээр нь сургуулийн өргөтгөл барих, ачааллыг бууруулах, төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэхтэй шууд холбогдож байна.

3.3 Сурах орчин сайнаар үнэлэгдсэн сургуулийн сурагчдын сурлагын чанарын хувь

Судалгааны дүнгээс харахад сургуулийн удирдлага, багш нар, сурагчид, эцэг, эх \Нийт оролцогчдын 90,8 хувь\ бүгд сурах орчинг сайжруулвал, сургалтын чанарт сайнаар нөлөөлнө гэж үзэж байна. Үүнд: сургуулийн удирдлагын 84 хувь, багш нарын 91 хувь, сурагчдын 93.3 хувь, эцэг, эхийн 83.3 хувь нь сурах орчин сайнаар үнэлэгдсэн сургуулийн сурагчдын сурлагын чанар сайжирна гэж, сайжрахгүй гэж нийт оролцогчдын 0.02 хувь нь үзсэн байна.

График 18: Сургалтын орчин, сурлагын чанарын хамаарлын талаарх судалгааны дүн



Хүснэгт 5: Сурлагын чанарын үзүүлэлт \2016-2017 он XII анги\

	сургуулиуд	17	24	53	62	84	Ирээдүй цогцолбор
1	Бүгд	805	749	1050	1260	4191	5425
2	Дээд	343	539	755	491	3224	2006
		42.6%	71.9%	71.9%	38.9%	76.9%	36.9%
3	Дундажаас дээш	255	194	250	532	913	2102
		31.6%	25.9%	23.8%	42.2%	21.7%	38.7%
4	Дундаж	133	14	44	205	52	878
		16.5%	1.8%	4.1%	16.2%	12.4%	16.1%
5	Дундажаас доош	74	2	1	32	2	438
		9.1%	0.02%	0.09%	2.5%	0.04%	8.0%

6	хангалтгүй	0	0	0	0	0	1	0.01%
---	------------	---	---	---	---	---	---	-------

Сурлагын чанарын дээд үзүүлэлтийг Нийслэлийн төвийн 24, Баянзүрх дүүргийн 53, 84 дүгээр сургуулийн сурагчид үзүүлсэн бол дундажаас доош үзүүлэлтийг гэр хорооллын болон холимог байршлын сургуулиуд үзүүлсэн байна.

3.4 Сурах орчинг сайжруулахад зарцуулж буй төсөв

Үнэлгээ хийгдсэн дүүргүүдийн удирдлага, сургуулийн захирал, багш нар сургалтын орчинг сайжруулж, стандартын шаардлагыг хангахад хамгийн чухал зүйл нь төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургуулиудын ачааллыг багасгах гэсэн нийтлэг хариултуудыг өгсөн болно.

Нийслэл, дүүргийн удирдлагууд “Нийслэлийн боловсрол-2020”, “Чингэлтэйн боловсрол-2020” дэд хөтөлбөрүүдийг 2017 онд баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэж эхэлсэн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах боломжийг бүрдүүлж байна.

Мөн Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд боловсролын салбарыг хөгжүүлэх зорилтуудаа тодорхойлсон байна.

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” батлагдахаас өмнө батлагдсан үндэсний хөтөлбөрүүд нь жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын бодлоготой тэр бүр уялдахгүй, сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газар бүр зорилго, чиглэлийг нь өөрчилдөг байсан учраас үндсэн нэгжүүд нь хэрэгжүүлэх ажлыг цалгардуулах байдалд хүргэжээ. Өөрөөр хэлбэл салбарын хөтөлбөрүүд нь Улсын Их Хурал, Засгийн газраар батлагдахдаа зорилтын түвшинд батлагдаж, төсөв, хөрөнгийг нь нарийвчлан тусгадаггүй. Тухайн жилийн боловсролын салбарын төсвийг Засгийн газраас боловсруулж, батлуулахдаа зөвхөн хөрөнгө оруулалт, урсгал зардлыг тусгаад, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг бараг тусгадаггүй байдал ажиглагдаж байна. Сангийн яам төсвийг хянаж нэгтгэхдээ зардлыг өмнөх оныхоос төдийлөн нэмэхгүй байх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхдээ хөтөлбөрт тусгасан ажлыг орхигдуулах байдал гарч байгааг салбарын яамны мэргэжилтнүүд дурьдаж байв. Бодлогын хөтөлбөр нь нэг шугамаар батлагдаад, төсөв боловсруулах, батлах ажил нь өөр шугамаар хийгдэж, хоорондоо уялдахгүй байгаа нь төрийн үйлчилгээний бүх салбарт хүндрэл учруулж байна.

Үндэсний түвшинд хөтөлбөр батлах, түүнийг санхүүжүүлэх ажил уялдахгүй байгаа нь орон нутгийн түвшинд мөн давтагдаж байна. Өмнө нь боловсролын бүх асуудлыг салбарын яам нь хариуцдаг байсан тогтолцоо одоо ч үргэлжилж байгаагаас салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн нэгждээ хүндрэлтэй, орон нутгийн төсвөөс асуудлыг шийдвэрлэх боломж нь хомс байдаг.

Хөтөлбөрийн биелэлтийг явцад нь болон төгсгөлд нь үнэлгээ хийлгүйгээр дараагийн хөтөлбөр батлагддаг жишиг тогтсон учраас хэрэгжилтийн байдлыг ямар нэгэн хуралдаанаар хэлэлцэж, шийдвэр гаргасан, ололт, амжилт, алдаа, дутагдал, зарцуулсан хөрөнгө зэргийг дүгнэж, хэлэлцсэн баримт дүүргийн түвшинд алга байна.

Дүүргийн боловсролын хэлтэс, сургуулиуд бодлогын бичиг баримтын хэрэгжилтэд хяналт тавих дотоод журамгүй, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хөтөлбөрийн биелэлтийг төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шалгалтын хэлтэс хариуцдаг учир асуудлыг бие бие рүүгээ түлхсэн байдалтай, боловсролын чиглэлийн хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг нэгдсэн байдлаар зохицуулах, хариуцлага хүлээх бодлого үгүйлэгдэж байна.

Сургуулийн удирдлага нь сургах үйл ажиллагаандаа гол анхаарлаа чиглүүлдэг, тухай бүр дээд удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх хэмжээнд ажлаа төлөвлөж, хийдэг учраас одоо мөрдөгдөж буй стандартуудыг тэр бүр мэдэхгүй, холбогдох хөтөлбөр, дүүргийн удирдлагаас гаргасан шийдвэрийн талаарх ойлголт сайнгүй байлаа. Одоогоор сургуулиудын хөрөнгө оруулалтын асуудлыг зөвхөн улсын болон нийслэлийн төсвөөс шийдвэрлэдэг, сургуулиуд гүнзгийрүүлсэн сургалтын төлбөрөөс зарим тулгамдсан асуудлаа шийдвэрлээд явж байна.

IV. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Төслийн баг 6 сургуулийн ажилтнуудтай хамтран сургуулийн гадаад орчин, дотоод орчинд болон сургуулийн барилгын гол бүрдэл хэсгүүд гэсэн үзүүлэлтүүдийг хамруулсан хяналтын хуудсаар хийсэн үнэлгээ, суурь судалгааны дүнг үндэслэн дараах дүгнэлтэнд хүрлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн орчны эрсдэлгүй байдал нийслэлийн дүүргүүдэд байршлаас хамааран ялгаатай байна. Судалгаанд хамрагдсан сургуулиудаас Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолборын 1 дүгээр ахлах сургууль, Сүхбаатар дүүргийн 24 дүгээр сургууль, Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургуулийн орчны стандартын хэрэгжилт харьцангуй сайн, сургуульд ажиллагсад болон суралцагсдын ажиллаж, суралцах орчин нь илүү тохитой байна.

Хүснэгт 6: Боловсролын үйлчилгээний орчныг хяналтын хуудсаар үнэлсэн дүн

Сургуулиуд	17-р сургууль		24-р сургууль		53-р сургууль		84-р сургууль		62-р сургууль		Ирээдүй цогцолбор	
	Стандартыг хангаж байгаа гэж хариулсан тоо	Стандартыг хангаагүй гэж хариулсан тоо	Стандартыг хангаж байгаа гэж хариулсан тоо	Стандартыг хангаагүй гэж хариулсан тоо	Стандартыг хангаж байгаа гэж хариулсан тоо	Стандартыг хангаагүй гэж хариулсан тоо	Стандартыг хангаж байгаа гэж хариулсан тоо	Стандартыг хангаагүй гэж хариулсан тоо	Стандартыг хангаж байгаа гэж хариулсан тоо	Стандартыг хангаагүй гэж хариулсан тоо	Стандартыг хангаж байгаа гэж хариулсан тоо	Стандартыг хангаагүй гэж хариулсан тоо
Сургуулийн гадаад орчин	12	5	12	5	7	10	12	5	7	10	13	4
Сургуулийн дотоод орчин	12	2	12	2	9	5	12	2	10	4	12	2
Барилга, материаллаг бусад нөөц	8	11	8	11	6	13	8	11	11	8	19	-
Дүн	32	18	32	18	22	28	32	18	28	22	44	6

Үнэлгээний дүнгээс харахад сургуулиудад стандарт болон норм, нормативуудын хэрэгжилт “дунд” буюу 63.3 хувьтай байна. Яамнаас санхүүжилт авдаг, гүнзгийрүүлсэн сургалттай, лаборатори сургуулиудад сурах орчин харьцангуй сайн, харин хотын төвөөс

зайдуу, сурагчдын тоо хүчин чадлаас хэтэрсэн сургуулиудад шийдвэрлэх асуудлууд их байна.

Ялангуяа сургуулийн дотоод орчинд стандарт болон нормативуудын хэрэгжилт хангалтгүй байгаа гэж үнэлсэн нь сурагч, багш нарын ажиллах, сурах анги, танхимын хүрэлцээ муу, ариун цэврийн өрөөний тоо хангалтгүй, сурагчид дугуйлан, секцэнд хамрагдах боломж хомс, дадлагын хичээл хийх бодис, материал, багаж, техник хэрэгслэл дутагдалтай, биеийн тамирын заалын ачаалал их зэргээс шалтгаалсан гэж үзэж байна.

Сургуулийн гадаад орчинд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хальтиргаа гулгааг багасгах, авто машины хөдөлгөөнийг зохицуулах, гэрэлтүүлгийг сайжруулах хэрэгтэй гэсэн дүгнэлт хийсэн болно.

Боловсролын үйлчилгээний хэвийн ажиллагаа хангагдахгүй байгаагийн гол шалтгаан нь анги дүүргэлт ихсэх, 3 ээлжээр хичээллэх явдал бөгөөд энэ асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй тохиолдолд сургуулийн гадаад болон дотоод орчны эрсдэлгүй, тааламжтай байх нөхцөл бүрдэхэд хүндрэлтэй байна.

Боловсролын салбарт хөтөлбөр болон стандартуудыг батлахдаа түүнийг хэрэгжүүлэх төсөв, хөрөнгийг хамтад нь шийдвэрлэдэггүй, салбарын болон орон нутгийн төсвийн төсөөллийг боловсруулах, батлахад сургалтын орчны шаардлага, стандартыг харгалзан үзэхгүй байгаагаас хэрэгжилт нь сайнгүй байна. Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдсэн, нийслэл хотын төвлөрөл их болсон зэрэг нь боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалт, барилга байгууламж, тоног төхөөрөмж, урсгал төсвийн хэрэгцээг эрс нэмэгдүүлж байна. Энэхүү өсөлтийн хурдыг одоогийн төсвийн хүрээнд шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.

Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, сонгуулийн үр дүнгээр бодлого өөрчлөгдөж, боловсон хүчний халгаа, сэлгээ их хийгддэг зэрэг нь бодлогын тогтвортой хэрэгжилт, залгамж байдалд сөргөөр нөлөөлж байна. Боловсролын чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, мөрдөгдөж байгаа стандартуудын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийхэд төрийн байгууллагын албан тушаалтнууд холбогдох эрх зүйн баримт бичгээ сайн судлаагүй, мэдээлэл өгөхөд бэлэн биш байсан.

Эрх зүйн баримт бичгийг үндсэн нэгжид хүргэх, сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх тогтсон журамгүй, нэг асуудлыг олон газарт хувааснаас төрийн албан хаагчдын дунд асуудлыг орхигдуулсан, бие биерүүгээ түлхсэн, төрийн бус байгууллагыг тээршаасан байдал анзаарагдаж байсан.

ЗӨВЛӨМЖ

Хийгдсэн үнэлгээний үр дүнгээр дараах зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд

1.Сургуулийн орчны стандартыг хот, хөдөө, хотын төв болон гэр хорооллын онцлогийг харгалзан боловсруулж 2018 онд багтаан батлуулах, одоо мөрдөгдөж байгаа стандартуудыг боловсролын байгууллагуудад хүргэх, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулахад анхаарах;

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу боловсролын чиглэлээр батлагдсан хууль, тогтоол, хөтөлбөр, стандартыг салбарын удирдлага, ажилтнуудад хүргэх, сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, үнэлгээ хийж байх ажлыг чанаржуулах;

3. Боловсролын талаар төрөөс баримталж байгаа бодлого нь сонгуулийн бүрэн эрхийн хугацаагаар өөрчлөгдөж, хүүхдүүдийг тогтвортой хөтөлбөрөөр системтэй сургахгүй байгаа, энэ салбарт ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудыг улс төрийн шалтгаанаар чөлөөлж, томилж байгаа одоогийн тогтолцоог өөрчлөх, ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежерээр ажиллах хүмүүст мэргэжлээрээ 3-5 жил ажилласан байх шалгуурыг бий болгох зэрэг асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар судлан шийдвэрлэх;

4.Сургуулийн техник хэрэгслэл, ширээ, сандал, бусад эд зүйлсийг худалдан авах, худалдах зарим эрхийг нийслэл, дүүрэг, сургуулийн удирдлагад шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.

Хоёр. Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, хэлтсийн удирдлагад

1. Монгол Улсын стандарт MNS 6444:2014 буюу "Сургуулийн бүс"-ийн техникийн ерөнхий шаардлагын дагуу сургуулийн орчинг тохижуулах, хүүхдийг зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулах;

2. Боловсролын асуудлаар гарсан эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг нэгтгэн зохион байгуулах үүргийг дүүргийн Боловсролын хэлтсийн дүрэмд тусгах; бодлогын бичиг баримтыг үндсэн нэгж, сургуулийн багш нар, эцэг, эхэд хүргэж сурталчлах, тухайн нэгжээс хийх ажлын төлөвлөгөөнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой асуудлыг тусгадаг байх;

3. Сурах орчныг бүрдүүлэх чиглэлээр батлагдсан хууль тогтоомж болон орчны стандартын талаар багш, сурагч, эцэг, эхэд сургалт зохион байгуулах, хийгдэж байгаа ажлын талаар оролцогч талуудад тухай бүр мэдээлж байх.

Гурав.Ерөнхий боловсролын сургуулиудын удирдлагад

1. "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.18 дахь хэсэгт "Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж, жил бүр

сургуулийн зөвлөл, багш нар, эцэг, эх, сурагчдын оролцоотойгоор боловсролын үйлчилгээний орчны стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүнг оролцогч талуудад мэдээлж байх, гарсан шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах;

2. Сургуулийн багш, ажилтнууд, сурагчид, эцэг, эхэд сурах орчны чиглэлээр сургалт зохион байгуулах, үнэлгээ хийх аргачлалын дагуу дотоодын хяналтыг зохион байгуулах талаар тус төрийн бус байгууллагатай хамтран ажиллахыг зөвлөж байна.

ХАВСРАЛТ

хавсралт 1: Ажлын төлөвлөгөө, удирдамж

хавсралт 2: Сургуулийн орчинг зохицуулсан Олон Улсын болон Монгол Улсын стандарт, сургуулийн барилга, эрүүл ахуйн чиглэлээр батлагдсан норм, нормативуудын жагсаалт

хавсралт 3: Үнэлгээ хийсэн сургуулиудын талаарх товч танилцуулга

хавсралт 4: Үнэлгээний хэрэглэгдэхүүн /мэргэжилтнүүд, сургуулийн удирдлага, багш, үйлчилгээний ажилтнууд, сурагчид, эцэг эхээс ганцаарчилан болон бүлгээр хийх ярилцлагын асуултын загвар

хавсралт 5: Сургуулийн үйлчилгээний орчны стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх хяналтын хуудас

хавсралт 6: Сонгинохайрхан дүүрэгт хийсэн үнэлгээний ажлын тайлан

хавсралт 7: Чингэлтэй дүүрэгт хийсэн үнэлгээний ажлын тайлан

хавсралт 8: Баянзүрх дүүрэгт хийсэн үнэлгээний ажлын тайлан

хавсралт 9: Сургуулиудад ажиглалт хийсэн фото зурагнууд